



ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний хувьд тухайн үндсэн мэргэшлийн чиглэлээр 10-с доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
2. Илтгэл, өгүүлэл 5-аас доошгүй хэвлүүлсэн байх /Сүүлийн 5 жилд, өгүүлэл, илтгэл, гэрчилгээ эх хувиар нь авчрах/;
3. Оношилгоо, эмчилгээнд нэвтрүүлсэн шинэ арга, аргачлал 2-оос доошгүй байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Илтгэл, өгүүлэл 10 –аас доошгүй хэвлүүлсэн байх /Сүүлийн 5 жилд/;
2. Оношилгоо, эмчилгээнд нэвтрүүлсэн шинэ арга, аргачлал 3-аас доошгүй байх;
3. Олон улсын хуралд 1-ээс доошгүй илтгэл, өгүүлэл тавьсан байх; /Сүүлийн 5 жилд/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

Нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэг болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний нарын тухайд :

1. Сургалт, эрдэм шинжилгээний ажилд судлаач, багшлах чадвартай байх;
2. Ном, гарын авлага- 1, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны илтгэл 20-иос доошгүй бичиж, хэлэлцүүлсэн мэргэжлийн эмч нарын хүртээл болгосон байх;
3. Тухайн мэргэшлээрээ 5-аас доошгүй эмч дагалдуулан сургасан байх.

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын үндсэн мэргэшилийн чиглэлээрээ ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд:

1. Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны илтгэл 15-аас доошгүй бичиж хэлэлцүүлж салбарын эмч нарын хүртээл болгосон байх;
2. Өөрийн хариуцсан бүс, аймагт урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээний чиглэлээр зохион байгуулсан сургалтад багшилсан байх;.
3. Тухайн мэргэшлээр 2-оос доошгүй эмч дагалдуулан сургасан байх.